



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2014 оны 08 сарын 13 өдөр

Дугаар А/46

Улаанбаатар хот

### Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 75 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/520 дугаар захирамж, Нийслэлийн эдийн засаг, нийгмийн 2014 оны зорилтын 3.4.1.7, тус газрын дүрмийн 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Нийслэлийн 375 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын төлөвлөгөөнд тусгагдсан “Тэйст оф ЮБи” олон орны хоолны өдөрлөг зохион байгуулах ажлыг уг арга хэмжээний санаачлагч Бэнкэл ХХК-иар гэрээ байгуулан гүйцэтгүүлэхийг Үйлчилгээний байгууллага хариуцсан мэргэжилтэн /С.Туул/-д даалгасугай.

2. “Тэйст оф ЮБи” олон орны хоолны өдөрлөг зохион байгуулах зардлын төсвийг хавсралтаар баталсугай.

3. Гэрээт ажлыг гүйцэтгэхэд шаардагдах зардлын төсөв 11,130,000 /арван нэгэн сая нэг зуун гучин мянган/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг ахлах нягтлан бодогч /П. Ариунаа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Э.БАТТУЛГА

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын  
даргын 2014 оны 28 дугаар сарын  
15 өдрийн 1/8 тоот тушаалын хавсралт



НИЙСЛЭЛИЙН 375 ЖИЛИЙН ОЙН ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ  
“TASTE OF UB” ОЛОН ОРНЫ ХООЛНЫ ӨДӨРЛӨГИЙН ТӨСӨВ

№	Зардлын төрөл		Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	Тохижилтын зардал			7,850,000₮	7,850,000₮
2	Хэвлэл, мэдээлэл сурталчилгаанд	Хотын самбар	2 ш	450,000₮	900,000₮
		Зурагт хуудас	100 ш	2,000₮	200,000₮
		Хулдаасан хэвлэл	18	10,000₮	180,000₮
4	Хөтлөгчийн зардал		2 өдөр	600,000₮	600,000₮
5	Циркийн үзүүлбэр, урлагийн тоглолт		2 удаа	1,000,000₮	1,000,000₮
7	Туслах ажилчдын хөлс		10	40,000₮	400,000₮
Нийт				11,130,000₮	

ТӨСӨВ ЗОХИОСОН:  
НАЖГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН

С.ТУУЛ

ХЯНАСАН:  
АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ

П.АРИУНАА